



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,  
БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**



Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн Газар (цаашид Талууд гэх).

Аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжин хоёр улсын найрсаг харилцааг бэхжүүлэх, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэхийг эрмэлзэн,

Дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

#### **Нэгдүгээр зүйл**

Талууд дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж бэхжүүлнэ.

#### **Хоёрдугаар зүйл**

Талууд хоёр орны аялал жуулчлалын асуудал хариуцдаг албан ёсны байгууллага болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн хоорондын хамтын ажиллагааг дэмжинэ.

#### **Гуравдугаар зүйл**

Талууд хоёр орны хооронд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, жуулчны байгууллага, аялал зохион байгуулагч, зочид буудал, жуулчдын байр болон тээврийн асуудал эрхэлдэг компаний аялал жуулчлалын үйлчилгээ, үйл ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.

#### **Дөрөвдүгээр зүйл**

Талууд хоёр улсын аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын дэд бүтэц, байгууламжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Аялал жуулчлалын салбарын үзэсгэлэн яармаг, хурал зөвлөлгөөнд хамтран оролцох, хамтарсан судалгаа хийх, төсөл хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжинэ.

#### **Тавдугаар зүйл**

Талууд аялал жуулчлалын салбарын дараах чиглэлийн мэдээлэл харилцан солилцох явдлыг дэмжинэ. Үүнд:

а/ аялал жуулчлалын сурталчилгаа;



- б/ хоёр орны аялал жуулчлалын үйлдвэрлэл, аялал жуулчлалын нөөц;
- в/ аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл;
- г/ хоёр орны аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, байгалийн болон соёлын өвийн хадгалалт, хамгаалалт;
- д/ аялал жуулчлалын салбарын судалгаа, сургалт.

#### **Зургадугаар зүйл**

Талууд зааварлагч, оюутан, судлаач, мэргэжилтэн, сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн төлөөлөгч солилцох, аялал жуулчлалын салбарын албан тушаалтан, мэргэжилтэнд зориулсан семинар зохион байгуулах замаар аялал жуулчлалын салбарын судалгаа, сургалт явуулах талаар хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжинэ.

#### **Долдугаар зүйл**

Талууд гуравдагч орны зах зээлд аялал жуулчлалын үйлдвэрлэл эрхлэх, гуравдагч орны жуулчдыг өөрсдийн оронд аялуулах талаар хамтран ажиллахыг дэмжинэ.

#### **Наймдугаар зүйл**

Талууд дотоодынхоо хууль тогтоомжийн дагуу харилцан адил байх зарчмын үндсэн дээр нутагт дэвсгэр дээрээ аялал жуулчлалын албан ёсны товчоо байгуулан ажиллуулахыг дэмжинэ.

#### **Есдүгээр зүйл**

Талууд энэхүү Хэлэлцээрийг үр ашигтай хэрэгжүүлэх үүднээс Ажлын хэсэг байгуулж болно. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны арга хэлбэрийг Талууд харилцан тохиролцоно.

#### **Аравдугаар зүйл**

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл болон хамтран ажиллах арга хэлбэрийг Талууд харилцан тохиролцоно. Тусгай төсөл болон хамтын ажиллагааны талаарх тодорхой мэдээлэл, хэрэгжүүлэх арга хэлбэрийг Талууд болон тэдгээрийн агентлагууд тохиролцож болно.





### Арван нэгдүгээр зүйл

1. Талууд Хэлэлцээрийг ёсчлох тухай дотоодынхоо хууль тогтоомжийн заалтыг биелүүлсэн тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн өдрөөс эхлэн энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

2. Хэлэлцээр таван (5) жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд аль нэг Тал энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухайгаа хүчин төгөлдөр хугацаа дуусахаас 6 сарын өмнө дипломат шугамаар бичгээр нөгөө Талдаа мэдэгдээгүй бол Хэлэлцээр дараа дараагийн таван (5) жилд аяндаа сунгагдана.

Дор гарын үсэг зурагсад нь холбогдох Засгийн газраасаа олгосон зохих ёсны эрхийн дагуу дээр дурдсаныг нотлон энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү Хэлэлцээрийг Сөүл хотноо 2003 оны 11 дүгээр сарын 24 – ний өдөр монгол, солонгос, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд бүх бичвэрүүд адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлах явцад санал зөрвөл англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН  
ӨМНӨӨС

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ӨМНӨӨС